

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай бүлгүүдийг тус тус нэмсүгэй.

1/ “ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ**Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх**

28¹ дугаар зүйл.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох.

28¹.1.Баяжуулалтын үйл ажиллагааг баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхэлнэ.

28¹.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд энэ хуулийн 28¹.1-д заасан баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй.

28¹.3.Ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны явцад үүсэх үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглана.

28¹.4.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргагч энэ хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

28¹.4.1.технологийн болон үйлдвэрлэлийн туршилтыг холбогдох стандарт, аргачлалын дагуу хийлгэсэн байх;

28¹.4.2.газар ашиглах эрхийн гэрчилгээтэй байх;

28¹.4.3.баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны түүхий эдийн нөөцийг шийдвэрлэсэн байх;

28¹.4.4.баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, технологийн зураг төсөлд энэ хуулийн 48.4-д заасны дагуу холбогдох шийдвэрийг гаргуулсан байх;

28¹.4.5.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлуулсан байх;

28¹.4.6.химийн бодисын хэрэглээг тодорхойлсон байх;

28¹.4.7.баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг батлуулсан байх;

28¹.4.8.баяжуулах үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх эхний жилийн хаалтын санхүүжилтийн баталгаа гаргуулсан байх.

28¹.5.Энэ хуулийн 28¹.4-т заасан шаардлага хангасан тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар 3 удаа сунгаж болно.

28² дугаар зүйл.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг.

28².1.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх эдэлнэ:

28².1.1.баяжмал, бүтээгдэхүүнээ худалдах;

28².1.2.тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах;

28².1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч зохих татварыг төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх;

28².1.4.энэ хуульд заасан бусад.

28².2.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

28².2.1.үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх;

28².2.2.химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу устгах;

28².2.3.газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөрийг бүрэн төлөх;

28².2.4.баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх, хаалтын санхүүжилтийг бүрдүүлэх, хаалтын санхүүжилтийн баталгаа гаргах;

28².2.5.баяжуулалтын үйл ажиллагааг мэргэшсэн мэргэжилтнээр ахлуулсан багаар удирдуулж явуулах;

28².2.6.энэ хуульд заасан бусад.

28².3.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техник, эдийн засгийн үндэслэл болон тухайн тусгай зөвшөөрөлд тэмдэглэснээс бусад төрлийн ашигт малтмал, гарал үүсэл нь тодорхойгүй ашигт малтмал баяжуулж, борлуулахыг хориглоно.

28².4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаанд энэ хуулийн 28¹.4-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

28³ дугаар зүйл.Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх

28³.1.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс хойш 90 хоногийн дотор техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан технологийн дагуу үйлдвэрийг барьж байгуулах ажлын төлөвлөгөөг

боловсруулж ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 48.6.2-т заасан хугацаанд хүргүүлнэ.

28³.2.Энэ хуулийн 28³.1-д заасан төлөвлөгөөний хүрээнд дэд бүтцийг бий болгох, үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай барилга байгууламжийг барьж байгуулах, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг угсарч суурилуулан, туршилт, тохируулга хийж, хэвийн ажиллагаанд бэлтгэнэ.

28³.3.Энэ хуулийн 28³.2-т заасан бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх ажил, бүрдүүлэх бичиг баримтыг энэ хуулийн 10.1.11-д заасны дагуу зохицуулна.

28³.4.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагаа явуулахад баяжуулалтын инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй байхаас гадна шаардлагатай тохиолдолд металлургич, химич мэргэжилтнийг ажиллуулна.

28³.5.Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн нь чанарын хувьд Монгол Улсын стандартад нийцсэн баяжмал, бүтээгдэхүүн байна.

28³.6.Энэ хуулийн 28³.5-д заасан баяжмал, бүтээгдэхүүний чанарыг итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээр тодорхойлно.

28³.7.Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, тоног төхөөрөмж, технологи өөрчлөгдсөн тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийж энэ хуулийн 28³.1.-д заасныг баримтална.

28⁴ дүгээр зүйл.Хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжид тавих шаардлага

28⁴.1.Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжийн гидротехникийн байгууламжийн зураг төслийг Усны тухай хууль, Барилгын тухай хууль, холбогдох барилгын норм, дүрэмд заасны дагуу боловсруулна.

28⁴.2.Хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжийн төрөл, хийц, байршлыг төлөвлөхөд дараах ерөнхий шаардлагыг баримтална:

28⁴.2.1.өндөршил, хэвгийжил, уур амьсгал, инженер-геологи, гидрогеологи, гидрологи, биологийн зэрэг бүс нутгийн газар зүй, байгалийн бусад нөхцөл байдлыг харгалзсан байх;

28⁴.2.2.хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзсан байх;

28⁴.2.3.далангийн техникийн байдал, байгалийн хүчин зүйлийн нөлөөг тогтмол хянах боломжтой байх;

28⁴.2.4.хаягдлын сангийн далангийн хамгаалалт, хашилт, шүүрэлт нэвчилтийн хяналт тогтвортой байх;

28⁴.2.5.үерийн уснаас хамгаалах, борооны усыг хуримтлуулах, дахин ашиглах бололцоог хангасан байх.

28⁴.3.Байгалийн аюул, гамшиг болсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хаягдлын сангийн далангийн байдалд иж бүрэн үзлэгийг зураг төсөлд тусгасан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

28⁴.4.Хаягдлын сангийн усны химийн найрлагыг хүлцэх хэмжээнд байгаа, эсэх талаар мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулна.

28⁴.5.Хаягдлын сангийн далангийн ашиглалт, хаялга бүрдүүлэлт, дараагийн шатны өргөтгөлийн суурь үүсгэж байгаа байдалд тогтмол хугацаанд зохиогчийн хяналтыг хийлгэнэ.”

2/ “ЗУРГААДУГААР¹ БҮЛЭГ

Уурхай, үйлдвэрийн хаалт

40³ дугаар зүйл.Уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа, түүний төрөл, төлөвлөлт.

40³.1.Ашигт малтмал ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаанд энэ хуулийн 10.1.14-т заасан журмын дагуу боловсруулж батлуулсан, хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

40³.2.Хаалтын үйл ажиллагаа дараах төрөлтэй байна:

40³.2.1.техник, эдийн засгийн үндэслэлд заасны дагуу уурхайн олборлолт болон баяжуулалтын үйл ажиллагааг дахин сэргээхгүй байдлаар хаах төлөвлөгөөт хаалт;

40³.2.2.давагдашгүй хүчин зүйл тохиолдсоны улмаас үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэлд заасан хугацаанаас өмнө ашигт малтмал олборлох болон баяжуулах үйл ажиллагааг дахин сэргээхгүй байдлаар хаах гэнэтийн хаалт;

40³.2.3.зах зээлийн нөхцөл байдал хүндэрсэн, ашиглалтын явцад хайгуулаар тогтоогдсон нөөц батлагдаагүй буюу нэмэлт хайгуул хийх шаардлагатай болсон, уул техникийн болон гидрогеологийн нөхцөл хүндэрсэн, ашиглалт, баяжуулалтын технологийн горим алдагдсан, технологийн шинэчлэл хийх нөхцөл, шаардлага үүссэн тохиолдолд ашигт малтмал олборлох болон баяжуулах үйл ажиллагааг дахин сэргээх боломжтой байдлаар хаах түр хаалт.

40³.3.Хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг дараах үе шатанд доор дурдсан байдлаар боловсруулж баталгаажуулна:

40³.3.1.ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг үндэслэсэн хаалтын менежментийн төлөвлөгөөг;

40³.3.2.баяжуулалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг үндэслэсэн хаалтын менежментийн төлөвлөгөөг;

40³.3.3.ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон ашигт малтмал, баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэсэн

бүтээгдэхүүн болон гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн үзүүлэлт, зардлыг тусган энэ хуулийн 40³.3.1, 40³.3.2-т заасан хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг уурхайн олборлолтын болон баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлснээс хойш 5 жил тутам тодотгох;

40³.3.4.техник, эдийн засгийн үндэслэлд өөрчлөлт оруулсан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг энэ хуулийн 40³.3.3-т заасан мөчлөгтэй уялдуулан тухай бүр 2 жилээс илүүгүй хугацааны дотор тодотгох;

40³.3.5.ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 40³.2.1-д заасан төлөвлөгөөт хаалтын үйл ажиллагааг эхлүүлэхээс 1 жилээс доошгүй хугацааны өмнө хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний тодотголыг хийх;

40³.3.6.энэ хуулийн 40³.2.2, 40³.2.3-т заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн санаачилгаар тодотгож болох ба ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үндэслэл бүхий шаардлагын дагуу холбогдох хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг тодотгоно.

40³.4.Хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг энэ хуулийн 40³.3-т заасны дагуу тодотгоход уурхайн хувьд олборлолтын үйл ажиллагааны, баяжуулах үйлдвэрийн хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бодит гүйцэтгэл, гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн зардлыг хаалтын санхүүжилтийн тооцооллын тодотголд хамруулна.

40³.7.Энэ хуулийн 40³.3.5-д заасан хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний тодотголыг боловсруулах явцад төслийг тухайн сум, дүүргийн Засаг даргад танилцуулсан байна.”

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйлүүдийг тус тус нэмсүгэй.

1/ “18¹ дүгээр зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, түүнийг бүртгэх

18¹.1.Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг төрийн захиргааны байгууллагын баталсан маягтаар гаргах бөгөөд түүнд дараах бичиг баримтыг хавсаргана:

18¹.1.1.өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, цахим шуудангийн хаягийг тусгасан өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт;

18¹.1.2.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;

18¹.1.3.үйлчилгээний хөлс төлсөн баримт;

18¹.1.4.төрийн захиргааны байгууллагаас батлагдсан загварын дагуу үйлдсэн талбайн зураг, солбицол;

18¹.1.5.энэ хуулийн 7.1-д заасан шаардлага хангасныг нотлох баримт.

18¹.2.Энэ хуулийн 18¹.1-д заасан бичиг баримтыг цахим хэлбэрээр илгээнэ.”

2/ “20¹ дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх

20¹.1.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 18¹-т заасан өргөдлийг хүлээн авмагц дор дурдсан ажиллагаа явуулна:

20¹.1.1.төрийн захиргааны байгууллага өргөдөл гаргагчаас ирүүлсэн хүсэлтийг хугацаагаар нь хянаж, дугаарлаж бүртгэнэ.

20¹.1.2.өргөдөл, түүнд хавсаргасан бичиг баримт нь энэ хуулийн 18¹.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтооно.

20¹.1.3.өргөдөл гаргасан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон буюу түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа эсэхэд шүүлт хийнэ.

20¹.2.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20¹.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 10 өдөрт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

20¹.2.1.өргөдөл нь энэ хуулийн 20¹.1.1-д заасан шаардлагад нийцсэн, өргөдөл гаргасан талбай нь 20¹.1.2-т заасан давхцалгүй бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтойг өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэж, төрийн байгууллагын цахим хуудсанд 30 хоног байршуулж уг талбайд тусгай зөвшөөрөл хүсэх бусад аж ахуйн нэгжүүдийн оролцох саналыг авна;

20¹.2.2.өргөдөл түүнд хавсаргасан бичиг баримт нь энэ хуулийн 20¹.1.1-д заасан шаардлагад нийцээгүй бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүйг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэх;

20¹.2.3.өргөдөл гаргасан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан, мөн түрүүлж ирүүлсэн өргөдөлд тусгагдсан талбайтай бүхэлдээ давхацсан бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүйг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэх;

20¹.2.4.өргөдөл гаргасан талбай нь түрүүлж ирүүлсэн өргөдөлд тусгагдсан талбайтай хэсэгчлэн давхацсан бол давхцаагүй хэсэгт нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх бөгөөд өргөдөл гаргасан этгээд уг талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтэй бол нэмэлт өргөдөл гаргах.

20¹.3.Энэ хуулийн 20¹.2.1-т заасан хугацаанд тухайн талбайд санал ирүүлсэн этгээдүүдийн дунд дуудлага худалдааг зарлан явуулах ба дуудлага худалдааг энэ хуулийн 10.1.23-т заасан журмаар зохицуулна;

20¹.4.Энэ хуулийн 20¹.3-т заасан дуудлага худалдаагаар шалгарсан этгээдэд Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мөн хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

20¹.5.Энэ хуулийн 20¹.2.1-т заасан хугацаанд бусад аж ахуйн нэгжүүдээс санал ирээгүй бол өргөдөл гаргасан этгээдэд Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мөн хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

20¹.6.Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөөгүй бол төрийн захиргааны байгууллага өргөдлийг бүртгэлээс хасаж өргөдөл гаргасан этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

20¹.7.Өргөдөл гаргасан этгээд эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлсөн бол төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдөрт багтаан хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

20¹.8.Хайгуулын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, талбайн хэмжээг тэмдэглэх бөгөөд олгогдсон талбайн булангийн цэгийн солбицол, тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна.

20¹.9.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, татварын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.”

3/ “30¹ дүгээр зүйл.Стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа

30¹.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын шинэ технологид шаардлагатай, эрэлт хэрэгцээ ихтэй ашигт малтмалын талаар судлан, стратегийн чухал ашигт малтмалд хамруулах саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

30¹.2.энэ хуулийн 30¹.1-д заасан саналыг үндэслэн стратегийн чухал ашигт малтмалын жагсаалтыг Засгийн газар батална.

30¹.3.байгалийн нөөц газар, дурсгалт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авсан газар болон улсын хилийн зурвас газарт улсын төсвийн хөрөнгөөр стратегийн чухал ашигт малтмалын суурь судалгаа хийхийг Улсын их хурал, Засгийн газар бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх;

30¹.4.стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг энэ хуулийн 3, 4 дүгээр бүлэгт заасны дагуу зохицуулна.

30¹.5.Стратегийн чухал ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох боломжтой талбайн мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт танилцуулна.

30¹.6.Засгийн газрын шийдвэрийг үндэслэн стратегийн чухал ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өргөдлөөр олгоно.”

4/ “42¹ зүйл.Олон нийтийн оролцоо

42¹.1.Хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

42¹.2.Иргэн, төрийн бус байгууллага геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцоно:

42¹.2.1.салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгд оролцох, санал, зөвлөмж өгөх;

42¹.2.2.салбарын байгууллагуудтай хамтарсан судалгаа хийх;

42¹.2.3.салбарын хүний нөөц, техник, технологийн хөгжил, чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах;

42¹.2.4.холбогдох төрийн байгууллагаас геологи, уул уурхайн салбарын талаар үнэн, зөв мэдээлэл авах;

42¹.2.5.эдийн засгийг хөгжүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр геологи, уул уурхайн салбарт төрөөс баримталж буй бодлогыг дэмжих, энэхүү бодлогыг алдагдуулах, зогсоох аливаа явцуу ашиг сонирхолд оролцохгүй байх;

42¹.2.6.ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, амьдрах орчин, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа, хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллагад мэдэгдэх, гомдол гаргах.”

3 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсгүүдийг тус тус нэмсүгэй.

1/ “5.9.Энэ хуулийн 8.1.4-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үүсмэл ордыг бусдад гэрээний дагуу ашиглуулж болох бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайн хил заагт багтаж байгаа үүсмэл ордыг бусдад шилжүүлэхийг хориглоно.”

2/ “5.10.Энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үүсмэл ордын төрийн эзэмшлийн хувийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Засгийн газрын зөвшөөрснөөр тогтооно.”

3/ “10.4.Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх, уул уурхайн технологийн зураг төсөл боловсруулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагааны журам батлах;”

4/ “17.8.Сонгон шалгаруулалтаар олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн босго үнэ нэг гектар тутамд 7,000 төгрөг, өргөдлөөр олгох талбайн дуудлага худалдааны босго үнэ нэг гектар тутамд 14,000 төгрөг байна.”

5/ “17.9.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны үр дүнгээр ашигт малтмалын хэтийн төлөв бүхий эрдсийн хуримтлал тогтоогдоогүй талбайг өргөдлөөр олгоно.”

6/ “17.10.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайд 2 удаагийн сонгон шалгаруулалт зарлаж, оролцогч оролцоогүй бол өргөдлөөр олгоно.”

7/ “17.11.Энэ хуулийн 17.10-т заасан өргөдлийн талбайн солбицлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.”

8/ “18.3.Энэ хуулийн 18.1-д заасан баримт бичгийг цахим хэлбэрээр хүсэлт хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээнэ.”

9/ “35.13.Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орчны бохирдлоос урьдчилан сэргийлнэ.”

10/ “35.14.Олон улсын байгаль орчин, нийгэм, засаглал зарчмыг баримтлан хариуцлагатай уул уурхайн кодексыг хэрэгжүүлж ажиллана.”

11/ “42.1¹.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нийгмийн хариуцлагын хүрээнд ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн боловсролд хөрөнгө оруулах зорилгоор хандив, тусламж өгөх тухай гэрээг тухайн сум, дүүргийн Засаг даргатай байгуулж болно. Хандив, тусламжийн нийт хэмжээ нь хайгуулын ажлын зардлын 1%-иас хэтрэхгүй байна.”

12/ “42.6.Нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн талбайгаас ашиг олох зорилгогүй түгээмэл тархацтай ашигт малтмалыг орон нутгийн бүтээн байгуулалтын хэрэгцээнд Засгийн газрын баталсан журмын дагуу ашиглаж болно.”

13/ “42.7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, Засаг дарга, холбогдох бусад төрийн байгууллага ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах үүрэгтэй.”

14/ “47.20.Үндсэн ашигт малтмалын тухайн төрөлд дагалдах байдлаар агуулагдаж байгаа, энэ хуулийн 9.1.21-т заасан жагсаалтад заагдаагүй эрдэс, химийн элементэд газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөр ногдуулахгүй.”

15/ “47.21.Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг төрийн өмчит хуулийн этгээд дангаар эрхлэх стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тухайд Улсын Их Хурал газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны

тусгай төлбөрийг тодорхой хугацаанд тогтоон тооцож улсын төсөвт төлүүлж болно.”

16/ “47.22.Энэ хуулийн 47.10-т заасны дагуу төсөвт төлсөн газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн 20 хувийг тухайн уул уурхайн төсөл хэрэгжиж буй сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.”

17/ “47.23.Энэ хуулийн 47.10-т заасны дагуу төсөвт төлсөн газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн уул уурхайн төсөл хэрэгжиж буй аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.”

18/ “47.24.Энэ хуулийн 47.22, 47.23-т заасан хувь хэмжээ стратегийн ач холбогдол бүхий ордоос гаргаж буй баяжмал, бүтээгдэхүүнд хамаарахгүй.”

19/ “48.15.1.бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон тайланг жил тутамд батлагдсан маягтын дагуу гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор, аймаг, нийслэлийн Засаг дарга нэгтгэн ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.”

4 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалтуудыг тус тус нэмсүгэй.

1/ “4.1.32.“стратегийн чухал ашигт малтмал” гэж олон улсын шинэ технологид шаардлагатай, эрэлт хэрэгцээ ихтэй ашигт малтмалыг;”

2/ “4.1.33.“түгээмэл тархацтай ашигт малтмал” гэж элбэг тархалт бүхий нуурын давс, хужир, шүү, шавар, элс, хайрга, дайрганы зориулалттай барилгын чулуу, боржин, хүрмэн чулуулгийн хуримтлалыг;”

3/ “4.1.34.”үндсэн ашигт малтмал” гэж ашигт малтмалаас технологи, эдийн засгийн хувьд ашигтайгаар ялгаж авах бололцоотой эрдэс, химийн элементийг;”

4/ “4.1.35.“эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмал” гэж химийн нэгдлийн хувьд үндсэн ашигт малтмалтай хамт үүсэж, хуримтлагдсан, дараагийн шатны технологийн боловсруулалтаар эдийн засгийн үр ашигтай ялган авах боломжтой эрдэс, химийн элементийг;”

5/ “4.1.36.“хаалтын үйл ажиллагаа” гэж ашиглалтын үйл ажиллагааны явцын нөхөн сэргээлт, уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоосноос хойш тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай болон үйлдвэрийн талбай дахь уурхай, овоолго, далан, бусад байгууламжийн физик, химийн тогтвортой байдлыг хангах, нөхөн сэргээлт хийх, орчны аюулгүй байдлыг хангах, хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтыг хийж гүйцэтгэх цогц арга хэмжээг;”

6/ “4.1.37.“хаалтын санхүүжилтийн баталгаа” гэж тухайн уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах санхүүгийн хэрэгслийг;”

7/ “4.1.38.“баяжуулалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу төрөөс олгосон баяжуулалтын үйл ажиллагаа явуулах эрхийг;”

8/ “4.1.39.“баяжуулалтын үйл ажиллагаа” гэж газрын хэвлийн баялгийг баяжуулалтын технологи ашиглаж явуулах үйл ажиллагааг;”

9/ “4.1.40.“техник, эдийн засгийн үндэслэл” гэж уул уурхайн төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн техник, технологийн шийдэл, эдийн засгийн үр ашиг болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон ашигт малтмалын орд болон түүний хэсгийг ашиглах, баяжуулах үйл ажиллагааг тусгасан баримт бичгийг;”

10/ “4.1.41.“зураг төсөл” гэж уурхай, үйлдвэрийн технологийн байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, үйл ажиллагааг иж бүрэн, нарийвчлан тооцсон баримт бичгийг;”

11/ “4.1.42.“зураг төсөл боловсруулах зөвшөөрөл” гэж технологийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах хуулийн этгээдэд олгох эрхийг;”

12/ “4.1.43.“маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” гэж геологи, уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтад шаардагдах хэмжилт, зураглалын ажил хийх хуулийн этгээдэд олгох эрхийг;”

13/ “9.1.18.стратегийн чухал ашигт малтмалын жагсаалтыг батлах;”

14/ “9.1.19.Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, хөтөлбөрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглах бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.”

15/ “9.1.20.газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөр ногдуулах эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн үндсэн ашигт малтмалын төрөл тус бүрээр Засгийн газар батална.”

16/ “9.1.21.газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөр ногдуулах эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын жагсаалтыг батлах;”

17/ “10.1.22.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, технологийн зураг төсөлд тавигдах шаардлагыг батлах;”

18/ “10.1.23.хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд дуудлага худалдаа зохион байгуулах журмыг батлах;”

19/ “11.1.29.түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиг олох зорилгогүйгээр орон нутгийн бүтээн байгуулалтын хэрэгцээнд ашиглах үед тухайн талбайн солбицлыг хянах;”

20/ “11.1.30.стратегийн чухал ашигт малтмалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх;”

21/ “11.1.31.орон нутагт геологи, уул уурхайн салбарын талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах;”

22/ “11.1.32.хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэдэд геологи, уул уурхайн чиглэлээр төрийн үйлчилгээг хүргэх;”

23/ “11.1.33.нутгийн захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын ажлын уялдаа холбоог хангаж ажиллах;”

24/ “11.1.34.тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайд жилд нэгээс доошгүй удаа газар дээр нь ажиллаж, энэ тухай тайлангаа ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлэх;”

25/ “18.1.9.төрийн захиргааны байгууллагаас батлагдсан загварын дагуу үйлдсэн талбайн зураг.”

26/ “21.1.9.хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд гүйцэтгэсэн ажлын мэдээллийг нийтэд цахимаар ил тод мэдээлэх;

27/ “27.1.15.тусгай зөвшөөрлийн талбайгаас өөрийн төслийн бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах;”

28/ “27.1.16.уурхайн уулын ажлын ахилтаар нөөцийн блок, давхарга нээхээс дуусах хүртэлх хугацаанд маркшейдерийн хэмжилт, блок, давхаргын ул, хананы сорьцлолт хийж баримтжуулан блок, нээсэн, хаасан акт тогтмол үйлдэж байх;”

29/ “32.4.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь жил бүр 10,000,000 төгрөг байна.”

30/ “47.1.4.бичил уурхай эрхлэгч;”

31/ “47.1.5.энэ хуулийн 9.1.19, 9.1.20-д заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан этгээд;”

32/ “48.6.3.ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн ажлын тухайн жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор;”

33/ “53.1.4.энэ хуулийн 48¹.2.2-т заасан гэнэтийн хаалт хийсэн;”

34/ “53.7.Энэ хуулийн 53.1.4 дэх заалт нь хайгуулын тусгай зөвшөөрөлд хамаарахгүй.”

5 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг тус тус өөрчлөн найруулсугай.

1/ “4.1.12."стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд" гэж цацраг идэвхт ашигт малтмал болон жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;”

- 2/** “4.1.23."бичил уурхай эрхлэх" гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон эрдсийн хуримтлалыг Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан аж ахуйн нэгж ашигт малтмал олборлох зорилгоор эрхлэх үйл ажиллагааг;”
- 3/** “6.3.Энэ хуулийн 4.1.33-т заасан ашигт малтмалын ордыг түгээмэл тархацтай ашигт малтмалын ордод хамааруулна.”
- 4/** “7.1.Хайгуул, ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.”
- 5/** “9.1.2.геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх болон стратегийн чухал ашигт малтмалын талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх;”
- 6/** “9.1.3.улсын тусгай хамгаалалттайгаас бусад газарт төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид уран болон газрын ховор ашигт малтмал эрэх, хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэх;”
- 7/** “10.1.1.геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх болон стратегийн чухал ашигт малтмалын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, биелэлтийг хангах;”
- 8/** “11.1.19.цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуул, ашиглалт болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох;”
- 9/** “11.1.25.энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах;”
- 10/** “11.2.Төрийн захиргааны байгууллагын геологийн асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.1 – 11.1.7, уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.8 – 11.1.12, 11.1.30, кадастрын асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.13 – 11.1.29, салбарын асуудал хариуцсан орон нутгийн дахь нэгж нь энэ зүйлийн 11.1.31-11.1.34-д заасан асуудлыг эрхэлнэ.”
- 11/** “17 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох өргөдлийн болон сонгон шалгаруулалтын талбайг ялгах;”
- 12/** “17.5.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн болон сонгон шалгаруулалт зарлах талбай нь дараах шаардлагыг хангасан байна.”
- 13/** “18.1.1.Сонгон шалгаруулалтад оролцогчийн хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, цахим шуудангийн хаягийг тусгасан албан ёсны тодорхойлолт;”
- 14/** “18.1.6.энэ хуулийн 7.1-д заасан шаардлага хангасныг нотлох баримт;”
- 15/** “21 дүгээр зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг”
- 16/** “21.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

17/ “22.1.3.байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн батлуулсан баримт;”

18/ “32.2.Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн гектар тутамд эхний жилд 1700 төгрөг, 2 дахь жилд 3400 төгрөг, 3 дахь жилд 5000 төгрөг, 4-6 дахь жилд тус бүр 17000 төгрөг, 7-9 дэх жилд тус бүр 26000 төгрөг, 10-12 дахь жилд 52000 төгрөг байна.”

19/ “32.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь талбайн гектар тутамд жил бүр 104000 төгрөг, шохойн чулуу, нүүрс, болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд гектар тутамд 34000 төгрөг байна.”

20/ “35.4.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авсны дараа ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ажиллуулж эхэлнэ.”

21/ “35.10 Ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн гэнэтийн осол, саатал, давагдашгүй хүчин зүйл, шүүхийн шийдвэр, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь зогсоосон болон бусад шалтгаанаар уурхайн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохдоо геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.”

22/ “40.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө сум, дүүргийн Засаг даргад батлуулахаар хүргүүлнэ.”

23/ “42.1.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар орон нутагтай хамтран ажиллах гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулж, аймаг, нийслэлийн Засаг дарга баталгаажуулна.”

24/ “42.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутагтай хамтран ажиллах гэрээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд орон нутгийн зүгээс хяналт тавихдаа олон нийтийн оролцоог хангасан байна.”

25/ “42.4.Нутгийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 42.1, 42.1¹-т заасан гэрээ, түүний хэрэгжилтийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана.”

26/ “47.2.1.экспортод уул уурхайн бүтээгдэхүүн гаргасан бол уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжсан арилжааны үнийн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн;”

27/ “47.2.2.энэ хуулийн 47.2.1-д заасны дагуу үнэлгээ тооцоогүй бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох

зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан;

28/ “47.3.1.дотоодын цахилгаан болон дулааны станцад худалдсан нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалд ногдуулах газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь;”

29/ “47.5 дахь хэсгийн хүснэгтийн 1 дэх мөрийг”

№	Ашигт малтмалын нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
1	Зэс	тн	Зэс /цэвэр металлээр	0-5000 хүртэл	0.00	0.00	0.0
				5000-6000 хүртэл	11.0	1.0	0.5
				6000-7000 хүртэл	12.0	2.0	1.0
				7000-8000 хүртэл	13.0	3.0	1.5
				8000-9000 хүртэл	14.0	4.0	2.0
				9000 ба түүнээс дээш	15.0	5.0	2.5

30/ “48.6.2.дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөөг батлагдсан зааврын дагуу 12 дугаар сарын 01-ний дотор;”

31/ “энэ хуулийн 48.6.3. гэснийг 48.6.4.”

32/ “53.1.Хайгуул, ашиглалт болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл дараах тохиолдолд дуусгавар болно.”

33/ “56.1.12.баяжуулах үйлдвэрийн хаалтын санхүүжилтийн тухайн жилийн баталгааг байршуулаагүй.”

6 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27 дахь заалтын "боловсруулахад" гэснийг "ашиглахад" гэж, 5 дугаар зүйлийн 5.3, 5.4, 5.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 47 дугаар зүйл, мөн зүйлийн 47.1, 47.3, 47.3.3, 47.6, 47.9, 47.10, 47.11, 47.12, 47.13, 47.15, 47.16, 47.17, 47.18, 47.19 дахь хэсэг, 47² дугаар зүйл, мөн зүйлийн 47².1, 47².2 дахь хэсэг, 47³ дугаар зүйл, мөн зүйлийн 47³.1, 47³.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.7.3, 48.9, 48.14 дэх хэсгийн “ашигт малтмалын нөөц ашигласны” гэснийг “газрын хэвлийн баялаг ашигласны” гэж тус тус өөрчилсүгэй.

7 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1. дэх хэсгийн “болон түгээмэл тархацтай” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “, 20” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “үйл ажиллагаа явуулж байгаа” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтын “болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох” гэснийг, 11.1.20 дахь заалтын “түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн” гэснийг, 11.1.25 дахь заалтын “сонгон шалгаруулалтын” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг тус тус хассугай.

8 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.6, 5.8 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.20 дахь заалт,

47³ дугаар зүйл, мөн зүйлийн 47³.1, 47³.2, 47³.3 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.13, 48.14 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ